

**“ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ” ХӨТӨЛБӨРИЙН  
2016 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**  
(2016 оны жилийн эцсийн байдлаар)

2017 оны 3 дугаар сарын 30

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл			
1.	<b>Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр</b> /2009-2017/- 2009.06.10 Засгийн газрын 173 дугаар тогтоол	<b>Хөтөлбөрийн зорилго:</b> Засгийн газар, хоршоо, хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, хоршоо хөгжих эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх замаар хоршооны нийгэмд гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, ажлын байр, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрийг эрчимтэй хөгжүүлэх, ажлын байр бий болгох.			
2.	<b>Санхүүжилтийн эх үүсвэр</b>	<ul style="list-style-type: none"> <li>➢ Улсын болон орон нутгийн төсөв;</li> <li>➢ Засгийн газрын тусгай сангийн хөрөнгө;</li> <li>➢ Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын зээл, тусламж, төслийн хөрөнгө;</li> <li>➢ Банк болон банк бус санхүүгийн байгууллагын эх үүсвэр;</li> <li>➢ Бусад эх үүсвэр</li> </ul>			
3.	<b>Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Жижиг, дунд үйлдвэрийн газар хариуцан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бодлогын удирдамжаар хангаж, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ хийнэ.</li> </ul> <p>Хэрэгжих хугацаа: -I үе шат 2009-2013 он; -II үе шат 2013-2017 он. Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Монголын Хоршоодын Үндэсний нэгдсэн холбоо.</p>			
	<b>Төсөл, хөтөлбөрийн зорилтууд</b>	<p>Зорилт 1. Хоршоог хөгжүүлэх чиглэлээрх хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох замаар хоршоодын хөгжлийг эрчимтэй дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;</p> <p>Зорилт 2. Хоршоодыг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;</p> <p>Зорилт 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, үр дүнг тодорхой тооцдог болгох;</p> <p>Зорилт 4. Хоршоодын бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг бий болгох;</p> <p>Зорилт 5. Хоршоодын мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, сургалт, сурталчилгааг төгөлдөржүүлэх.</p>			
5.	Зардал	<b>Төсөв (Нийт шаардагдах зардал)</b>	Төсвийн эх үүсвэр нь Улсын болон тусгай сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн болно.		
		Үүнд:	Төсөв /2009-2016/	Гүйцэтгэл	Хувь
		Зорилт 1	40,0 сая төг	50,0 сая төг	100
		Зорилт 2	2,5 тэрбум төг	4,8 тэрбум төг	100
		Зорилт 3	120,0 сая төг	250,0 сая төг	100
		Зорилт 4	80,0 сая төг	160,0 сая төг	100
		Зорилт 5	110,0 сая төг	240,0 сая төг	100
	<b>Нийт</b>	<b>2,85 тэрбум төгрөг</b>	<b>5,7 тэрбум төг</b>		
	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	5 зорилттой			
6	<b>Зорилт-1. Хоршоог хөгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох замаар хоршоодын хөгжлийг</b>	<p><b>1.1. Хоршооны тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Улсын их хурлын 2011-10-27-ны өдрийн хуралдаанаар “Хадгаламж зээлийн хоршооны тухай” хууль батлагдан хэрэгжиж байна.</li> <li>❖ Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай</li> </ul>			

<p><b>эрчимтэй дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх;</b></p>	<p>хуулийг 2011-06-02 нд, тус хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2011-06-02 –ний өдрийн 29 дугаар тогтоол баталсан.</p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Хоршооны хууль эрх зүйн орчинд мэргэжлийн байгууллагын шинжилгээ хийлгэх, сайжруулахаар мэргэжлийн хуулийн компани ажиллуулан, хоршооны хууль, эрх зүйн орчинд шинжилгээ хийж, “Хоршооны хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөл болон бусад холбогдох хууль тогтоомжид оруулах нэмэлт өөрчлөлтийн талаар холбогдох хэлэлцүүлгийг хийж эцэслэн 2012 оны 4 сард УИХ-ын дэд даргад өргөн барьсан. Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/40 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Хоршооны тухай” боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хоршоо болон хоршоог дэмжигч байгууллагуудаар хэлэлцүүлэн саналыг тусгаж боловсруулсан байна.</li> <li>❖ Хоршоологчдод үзүүлж буй татварын ачааллын талаар хоршоологчид болон хоршоог дэмжигч байгууллагуудаас санал авч нэгтгэн “Хоршооны тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж байгаатай холбоотойгоор дагалдаж өөрчлөгдөх “Аж ахуйн нэгжийн албан татварын тухай”, “Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай” хуулиудад санал боловсруулан Сангийн яаманд 2012-05-12-ны өдрийн Хөдөлмөрийн дэд сайдын албан тоотор хүргүүлэн ажиллав.</li> <li>❖ “Хоршооны тухай хуулийн хэлэлцүүлгийг 2014-10-20-нд Улаанбаатар зочид буудлын Өргөө танхимд хоршоод болон Глобал коммунити төсөл, хоршоодын холбоодын оролцоотой хамтран зохион байгуулав. Хэлэлцүүлгээр хуулийн шинэчилсэн хувилбарыг хэлэлцэж, батлуулахад шаардлагатай алхамуудыг хэрхэн зохион байгуулах талаар арга хэмжээ авахаар тохиролцов.</li> <li>❖ Төрөөс баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх чиглэсэн хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор анх 2010-04-23-ны өдөр Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоо болон Санхүүгийн Зохицуулах хорооны хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Улмаар 2014-04-24-ний өдөр хугацаагүйгээр шинэчлэн байгуулан, жил бүр шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулж, жил бүр хэрэгжилтийг дүгнэж ирсэн.</li> <li>❖ Монгол улсад хоршооллын хөдөлгөөнийг тогтвортой хөгжүүлэхэд хоршоологчид хөгжлийн нэгдсэн бодлогоор үйл ажиллагаагаа уялдуулан ажиллаж, улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулдаг, гишүүдийнхээ амьдралын чанарыг дээдэлсэн, байгаль орчинд ээлтэй, технологийн өндөр чадамж бүхий хоршоодыг эгнээндээ багтаасан хоршооллын хөдөлгөөнийг хөгжүүлэх санаачлагыг гаргаж 2010-06-30-ны өдөр “Хоршоологчдын Үндэсний 2-р чуулган”-ыг зохион байгуулж “Монголын хоршооллын салбарын дунд хугацааны /2010-2018 он/ стратегийн баримт бичиг”-ийг батлуулан гаргав.</li> <li>❖ Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүнчлэлийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг өргөжүүлэх, чадавхижуулах болон жижиг хадгаламж зээлийн хоршоодыг дэмжих зорилгоор 300 сая төгрөгөөс доош бөгөөд Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооны гишүүний хадгаламж, зээлтэй хоршоог Санхүүгийн Зохицуулах Хороонд жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлснөөс чөлөөлөх заалтыг тус хорооны 2015-04-01-ний өдрийн 158 тоот тогтоолоор батлагдсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам"-нд тусгахад хамтран ажилласан. Монголын хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооноос хүргүүлсэн саналыг</li> </ul>
---	--

		<p>үндэслэн Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Сангийн сайдын 2015-05-13-ны өдрийн 145/124 тоот хамтарсан тушаалаар Хадгаламж зээлийн хоршооны онцлогт нийцүүлэн “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” батлагдсан. Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргагч болон тусгай зөвшөөрөлтэй хоршоодод тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл авахад мөрдөгддөг журам, зааврыг хэрэглэхэд илүү ойлгомжтой, хялбар болгох, олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны 2015-11-23-ны өдрийн 405 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам"-ыг шинэчлэхэд холбогдох саналуудаа хүргүүлж хамтран ажиллав.</p> <p>❖ Нэгдсэн үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 64 дүгээр чуулганаас 2012 оныг “Олон улсын хоршооллын жил” /ОУХЖ/ болгон зарласантай холбогдуулан Монгол улсын Засгийн газраас “Хоршооллын олон улсын жилийг тэмдэглэх тухай” 2011-04-13-ны өдрийн 112 дугаар тогтоолоор Монгол улсын Шадар сайдаар ахлуулсан Үндэсний хорооны бүрэлдхүүн болон ажлын төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд хоршооны хууль эрх зүйн орчныг сайжруулах, Хоршоодын судалгаа үнэлгээг улсын хэмжээнд зохион байгуулж, үндэсний цахим мэдээллийн сан бий болгох, хоршоодын төрөлжсөн сургалт, сурталчилгааг хийх, гадаад дотоодын үзэсгэлэнд оролцоход нь дэмжлэг үзүүлэх, орон нутгийн засаг захиргааны мэдэлд байгаа газар, барилгыг жишиг хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор эзэмшүүлэх, ашиглуулах, жишиг хоршоодод хөнгөлөлттэй зээл, тоног төхөөрөмжийг лизингээр олгох гэх мэт НҮБ-ын Олон улсын хоршооллын жил”-д дэвшүүлсэн 3 гол зорилтуудын хүрээнд нийт 22 арга хэмжээ тусган хэрэгжүүлсэн.</p> <p>❖ Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр хоршооны салбарын асуудлыг хариуцах яам нь тодорхойгүйн улмаас 2015-2016 онд салбарын эрх зүйн орчинд хийгдэх арга хэмжээ орхигдсон байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ: 90</b></p> <p><b>1.2. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор зээлийн баталгаа, зээлийн даатгал, барьцааны тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг шинээр бүрдүүлэх;</b></p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго бүхий Зээлийн батлан даалтын сангийн тухай” хууль 2012-02-10-нд баталсан. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2012-11-06-нд Зээлийн батлан даалтын сан байгуулагдаж, 2012 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар 5 тербум төгрөгийн эх үүсвэр батлагдсан.</p> <p style="text-align: center;"><i>Гаргасан батлан даалт үйл ажиллагааны салбараар</i></p> <table border="1" data-bbox="627 1697 1498 2011"> <thead> <tr> <th>Үйл ажиллагааны салбар</th> <th>Зээлдэгчийн тоо</th> <th>Олгосон зээл</th> <th>Гаргасан батлан даалт /сая/</th> <th>Батлан даалтын эзлэх хувь</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Үйлдвэрлэл</td> <td>227</td> <td>48,137.01</td> <td>19,230.92</td> <td>49.91</td> </tr> <tr> <td>Үйлчилгээ</td> <td>59</td> <td>17,028.00</td> <td>6,952.42</td> <td>18.26</td> </tr> <tr> <td>Худалдаа</td> <td>96</td> <td>16,041.69</td> <td>6,643.04</td> <td>17.58</td> </tr> <tr> <td>Хөдөө аж ахуй</td> <td>57</td> <td>10,299.60</td> <td>4,925.77</td> <td>14.25</td> </tr> <tr> <td><i>Нийт</i></td> <td>439</td> <td>91,506.30</td> <td>37,752.15</td> <td>100.00</td> </tr> </tbody> </table> <p><i>Мэдээлэлийн эх үүсвэр: Зээлийн батлан даалтын сан</i></p> <p>❖ Санхүүгийн зохицуулах хорооны 2014-10-21-ний өдрийн 371 тоот тогтоолоор "Хадгаламж зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн</p>	Үйл ажиллагааны салбар	Зээлдэгчийн тоо	Олгосон зээл	Гаргасан батлан даалт /сая/	Батлан даалтын эзлэх хувь	Үйлдвэрлэл	227	48,137.01	19,230.92	49.91	Үйлчилгээ	59	17,028.00	6,952.42	18.26	Худалдаа	96	16,041.69	6,643.04	17.58	Хөдөө аж ахуй	57	10,299.60	4,925.77	14.25	<i>Нийт</i>	439	91,506.30	37,752.15	100.00
Үйл ажиллагааны салбар	Зээлдэгчийн тоо	Олгосон зээл	Гаргасан батлан даалт /сая/	Батлан даалтын эзлэх хувь																												
Үйлдвэрлэл	227	48,137.01	19,230.92	49.91																												
Үйлчилгээ	59	17,028.00	6,952.42	18.26																												
Худалдаа	96	16,041.69	6,643.04	17.58																												
Хөдөө аж ахуй	57	10,299.60	4,925.77	14.25																												
<i>Нийт</i>	439	91,506.30	37,752.15	100.00																												

		<p>бусад ажил, үйлчилгээний журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж хадгаламж зээлийн хоршоод нь хадгаламжийн болон зээлийн үйлчилгээнээс гадна лизингийн үйлчилгээ, даатгалын төлөөлөгч хийх зэрэг нэмэлт үйлчилгээг эрхлэх боломжтой болсон.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:90</b></p> <p><b>1.3. Албан бус хэвшилээс албан хэвшилд сайн дураараа шилжиж, хөрөнгө, хөдөлмөрөө хоршин ажиллах хүсэлтэй иргэдийн санаачилгыг дэмжиж, нийгмийн даатгал, халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх;</b></p> <p>❖ Хөтөлбөрийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлж, ажлын байранд зуучлах, тэдгээрийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох, хоршооны хэлбэрээр бизнес эрхлэхэд нь санхүүгийн дэмжлэг, зээл олгох зэрэг арга хэмжээнд 8000 гаруй хүнийг хамруулан, 5000 байнгын ажлын байрыг бий болгосон.</p> <p>❖ Нийслэлд хоршооны бүтэц бий болгох, хоршсон хөдөлмөр, албан бус хөдөлмөрөөс зохистой албан хөдөлмөрт шилжих санал санаачлагыг дэмжих зорилгоор Нийслэлийн Хөдөлмөрийн газар, Монголын Хоршооллын Үндэсний Нэгдсэн Холбоо Баянгол дүүргийн 2,6,18,21, Сонгинохайрхан дүүргийн 5,7, Багануур дүүргийн 1, Налайх дүүргийн 4, Баянзүрх дүүргийн 8, Чингэлтэй дүүргийн 12,16,17, Хан-Уул дүүргийн 12,13,14, Сүхбаатар дүүргийн 12, 17, 20 хороодын иргэдийг сургалт мэдээллээр хангаж ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:50</b></p> <p><b>1.4. Улсын тэргүүний хоршоо шалгаруулах журмыг шинэчлэн боловсруулж, хоршооны шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулах болзол гарган жил бүр дүгнэн урамшуулах.</b></p> <p>❖ Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж байгаа хоршоодын үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх, улмаар тэдэнд урам хайрлах, тэдний туршлагыг нь хуваалцаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилж таниулах зорилгоор Олон улсын хоршооллын өдөр буюу Үндэсний хоршооллын өдрөөр “Улсын шилдэг хоршоо” шалгаруулах журмыг шинэчлэн Засгийн Газрын 2013 оны 221 дүгээр тогтоолоор батлуулав.</p> <p>❖ Хөдөлмөрийн Сайдын 2013 оны А/235 тушаалаар улсын хэмжээнд 10 хоршоо, Аж үйлдвэрийн Сайдын 2015 оны 37 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр –П”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Улсын шилдэг хоршоо”-г шалгаруулах арга хэмжээг зохион байгуулан Хоршооллын хөдөлгөөний 21-р зуунд баримтлах үндсэн 7 зарчмын хэрэгжилтийг хангаж, хоршооны тогтвортой хөгжлийг бүрдүүлж, амжилт гарган бусдыгаа хошуучлан ажиллаж байгаа хоршоодыг жил бүр “Улсын шилдэг хоршоо”-оор шалгаруулан урамшуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:90</b></p>
		<b>1 дүгээр зорилтын дундаж үнэлгээ: 80</b>
	<p><b>Зорилт-2.Хоршоодыг эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;</b></p>	<p><b>2.1. Ажлын байр бий болгож, албан бус хөдөлмөр эрхлэлтийг хоршооны хэлбэрт шилжүүлэх замаар тухайн бүс нутагт импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа хоршоонд тоног төхөөрөмжийг лизингээр олгох, хөнгөлөлттэй зээл олгоход дэмжлэг үзүүлэх;</b></p> <p>❖ Хөтөлбөрийн хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлж, ажлын байранд зуучлах, тэдгээрийг ажлын байраар хангасан ажил олгогчид урамшуулал олгох, хоршооны хэлбэрээр бизнес эрхлэхэд нь</p>

**Хүрэх үр дүн:**Хоршоо болон түүний гишүүдийн тоо, тэдгээрийн үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт, хоршооны бүтээгдэхүүний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, түүний өсөлт;

санхүүгийн дэмжлэг, зээл олгох зэрэг арга хэмжээнд 8000 гаруй хүнийг хамруулан, 5000 байнгын ажлын байрыг бий болгосон.

❖ Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж, Хадгаламж зээлийн хоршоотой хамтран ажиллах анхны гэрээг байгуулсан. Зээлийн батлан даалтын сангийн үр дүнд 1539 ажлын байр шинээр бий болж 3876 ажлын байр хадгалагдсан байна.

*Олгосон зээл, батлан даалт, шинээр бий болсон, хадгалагдсан ажлын байр /оноор/*

Оноор	Батлан даалтад хамрагдсан аж ахуй нэгж, иргэн /тоо/	Батлан даалт гаргасан хэмжээ /тербум төгрөг/	Батлан даалт гаргасаны үр дүнд		
			Олгосон зээлийн хэмжээ /тербум төгрөг/	Шинээр бий болсон ажлын байр	Хадгалагдсан ажлын байр
2013	56	3.7	10.3	231	523
2014	261	17.2	39.3	861	1893
2015	86	8.8	22.5	284	795
2016	38	8.0	19.2	163	665
<b>Нийт</b>	<b>439</b>	<b>37.7</b>	<b>91.5</b>	<b>1539</b>	<b>3876</b>

*Мэдээлэлийн эх үүсвэр: Зээлийн батлан даалтын сан*

❖ Санхүүгийн Зохицуулах хорооны 2014-10-21-ний өдрийн 371 тоот тогтоолоор Хадгаламж зээлийн хоршоод нь хадгаламжийн болон зээлийн үйлчилгээнээс гадна лизингийн үйлчилгээ, даатгалын төлөөлөгч хийх зэрэг нэмэлт үйлчилгээг эрхлэх боломжтой болсон.

❖ Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 206 тоот тогтоолоор "Хадгаламж зээлийн хоршооны эрхлэх санхүүгийн бусад ажил, үйлчилгээний журам"-ыг боловсруулахад хамтран ажиллаж журамд ХЗХ-д санхүүгийн түрээс, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах зэрэг нэмэлт үйл ажиллагааг явуулах боломжтой болсон.

❖ Хоршоо хөтөлбөр хэрэгжснээр жилээс жилд хоршооны тоо өсөн нэмэгдэж 2012 онтой харьцуулхад хоршоодын тоо 1,5, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 1,7, хоршооны гишүүдийн тоо 1,4 дахин тус тус нэмэгдсэн байна.

**Хоршооны гишүүдийн тоо, хөрөнгийн хэмжээ, салбараар /2016 оны байдлаар/**

№	Хоршоо салбараар	Хоршооны тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгө /сая төг/	Гишүүдийн тоо
1	Хөдөө аж ахуй ан агнуур, ой аж ахуй	1313	12904.6	16215
2	Уул уурхай, олборлох үйлдвэр	4	11.0	26
3	Боловсруулах үйлдвэр	604	4056.4	6592
4	Цахилган хий үйлдвэрлэл, ус хангамж	5	120.0	29
5	Барилга	44	881.7	340
6	Бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны худалдаа	1462	10255.1	30457
7	Зочид буудал, зоогийн газар	67	617.8	1221
8	Тээвэр, агуулахын аж ахуй, холбоо	97	2838.0	1091



9	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	368	24473.0	20386
10	Үл хөдлөх хөрөнгө түрээс, бизнесийн үйл ажиллагаа	43	896.8	414
11	Боловсролын салбарын үйл ажиллагаа	9	13.6	39
12	Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа	202	956.7	1681
13	Нийгэм, бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээ	36	108.4	297
<b>Нийт</b>		<b>4254</b>	<b>58133.1</b>	<b>78788</b>

*Мэдээллийн эх сурвалж: Статистикийн эмхэлтгэл, Жижиг, дунд үлдвэрлэл, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар*

**Үнэлгээ: 100**

**2.2. Хоршооноос боловсруулсан эдийн засгийн үр ашиг бүхий төслийг шалгаруулж, зээл олгоход дэмжлэг үзүүлэх;**

❖ Орон нутагт мал аж ахуйн чиглэлийн хоршоодын үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, тус салбарыг эдийн засгийн үр ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хоршоодод 2,5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 4 жилийн хугацаатай, сарын 0,5 хувийн хүүтэйгээр олгохоор шийдвэрлэсэн. Хөнгөлөлттэй зээл олгох журмыг бүх аймаг болон нийслэлд хүргүүлж, төслүүдийг холбогдох журмын дагуу хүлээн авч 21 аймаг, нийслэлийн 221 төслийг сонгон шалгаруулж, хөнгөлөлттэй зээл олгож ажилласан байна.

❖ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны өдрийн А/132 тоот тушаалаар 93 хоршоонд 2,465 сая төгрөг;

❖ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2012 оны А/47 тоот тушаалаар 105 хоршоонд 943 220 000;

❖ Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны А/134 тоот тушаалаар 23 хоршоонд 500 000 000 төгрөгийн хөнгөлөлттэй зээл тус тус олгосон байна.

**Үнэлгээ: 90**

**2.3. Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа малчин, албан бус хөдөлмөр эрхлэгчид материал, түүхий эд, үр, бордоо, мал, тэжээвэр амьтан, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл зэргийг худалдан авахад нь зориулж хөнгөлөлттэй зээлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох;**

❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, хөдөлмөрийн зах зээлд томоохон байр суурь эзэлдэг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл, зээлийн батлан даалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгж болгож төлөвшүүлэх эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгосон ба уг сангаас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөр дамжуулан 10.4 мянган иргэнд 41 тэрбум төгрөгийн жижиг зээл олгосны дүнд 25.7 мянган ажлын байрыг шинээр бий болгосон. Энэ чиглэлээр Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх”, Хөдөө аж ахуйн олон улсын сангийн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслүүдтэй хамтран ажиллаж байна.

❖ Түүнчлэн 1.4 мянган ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байртай болгож, тогтвортой хадгалсан 1.2 мянган аж

<p>ахуйн нэгжид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>❖ 2016 оны байдлаар 4254 хоршоонд 78788 хоршоологчид гишүүнээр элсэж 58,1 тэрбум төгрөгийн хөрөнгө хувь нийлүүлсэн дундын хөрөнгөтэй болсон байна.</p> <p><i>Хоршооны гишүүдийн тоо, хөрөнгийн хэмжээ /2016 оны байдлаар/</i></p>			
Аймаг нийслэл	Хоршооны тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн тоо /сая төг/	Гишүүдийн тоо
Улаан-баатар	645	21241.9	13383
Орон нутаг	3609	36891,2	65405
<b>Дүн</b>	<b>4254</b>	<b>58133.1</b>	<b>78788</b>
<p><i>Мэдээллийн эх сурвалж: Статистикийн эмхэтгэл, Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар</i></p> <p>❖ Засгийн газрын 2012-12-28-ний өдрийн 74 дүгээр тогтоолоор баталсан “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” тогтоолд Малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох, хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох урамшуулалд шаардагдах хөрөнгийг 2013 оны төсвийн тодотголд тусгаж, цаашид мөнгөн урамшуулал болон үнэт цаасны хүүгийн зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох болон хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд урамшуулал олгох, түүнд хяналт тавих журмыг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллахаар тусгагдаж тус тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллав. Мөн тус дэмжлэгт хоршооны гишүүн бус малчид, мал бүхий иргэд хамрагдаж чадахгүй байсныг үндэслэн “Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 2016-05-19-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор “хоршооны гишүүн” гэснийг хассан болно.</p> <p><i>Малчдад олгосон ноосны урамшуулал</i></p>			
<i>Он</i>	<i>Малчны тоо</i>	<i>Ноосны хэмжээ /тн/</i>	<i>Мөнгөн дүн /тэрбум төгрөг/</i>
<b>2011</b>	32,977	4 924.9	9.8
<b>2012</b>	103,162	14 696.6	29.4
<b>2013</b>	117,667	18 307.3	36.6
<b>2014</b>	80,619	16 643.5	18.3
<b>2015</b>	79,407	16 897.0	19.3
<b>2016</b>	92,885	20 598.9	22.6
<b>ДҮН</b>	<b>506,717</b>	<b>87143.30</b>	<b>136</b>
<p><i>Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан</i></p> <p>❖ Малчдын орлого, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжих зорилгоор 2013-2015 онуудад Мал хамгаалах сангаас 132,4 мянган малчинд 20,4 тэрбум төгрөгийн арьс, ширний, 2011-2016 онд 189 үндэсний үйлдвэрт ноосоо тушаасан 506,7 мянган малчин, мал бүхий иргэнд 136 тэрбум төгрөгийн урамшуулал олгосны зэрэгцээ арилжааны банкаар дамжуулан малчдад шинээр олгох зээлийн хүүг 10 хүртэл хувь болгох, Төрийн банкнаас олгосон малчны</p>			

зээлийн хүүг 18 хүртэл хувь болгон бууруулах ажлыг зохион байгуулалтын арга хэмжээг авсан.

*Арьс, ширний урамшуулал:*


Он	Малчны тоо	Арьс, ширний тоо /ширхэг/		Олгосон мөнгөн дүн /тэрбум.төг
		Бод	Бог	
2013 /сүүлийн хагас/	29811	40620	700297	2,7
2014 /2 удаа/	62620	163460	1909127	8,2
2015 оны сүүлийн хагас жил	45061	168512	2324359	9,5
<b>Дүн</b>	<b>132492</b>	<b>372592</b>	<b>4934283</b>	<b>20,3</b>

*Мэдээллийн эх сурвалж: Мал хамгаалах сан*

❖ “Хөдөөг хоршоолох аян”, Засгийн газрын 2012 оны 95 дугаар тогтоол, Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн бэлтгэл ажлыг хангах, “Монгол мал” үндэсний хөтөлбөр болон “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-II”-өөс дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор сумдад үйл ажиллагаа явуулж буй хоршоодын үйл ажиллагааг үнэлсэн Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны үнэлгээ, тайлан болон төсөл сонгон шалгаруулах комиссын хуралдаанаас гарсан шийдвэрийг үндэслэн Үйлдвэр Хөдөө аж ахуйн Сайдын тушаалаар 105 “Жишиг хоршоо”-д 943,2 сая, Хөдөлмөрийн сайдын А/240 тушаалаар 12 хоршоонд 600,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэлээ.

❖ Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлээр 16 хоршоонд 386,0 сая төгрөгөөр 70 шинэ ажлын байр, “Сум хөгжүүлэх сан”-ийн эх үүсвэрээр 30 төслийг 425,6 сая төгрөгөөр 97 шинэ ажлын байр бий болгоход, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-ийн эх үүсвэрээр 11 хоршоонд санхүүгийн дэмжлэг үзүүлээ.

*Аж ахуйн нэгж байгууллагын тоонд Хоршоодын эзлэх хувь хэмжээ нэмэгдсэн.*



*Үнэлгээ:100*

**2.4. Мэргэжилтэй, ур чадвар бүхий ажилтан бэлтгэх, дэвшилтэт техник, технологи эзэмших сургалтын тогтолцоог бүрдүүлэх.**

❖ Германы Олон Улсын хамтын ажиллагааны “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрийн санхүүжилтээр Хоршоологчдын өдрийг угтаж “Хоршоологчдын нээлттэй өдөрлөг”-ийг Чингисийн талбайд зохион байгууллаа. Өдөрлөгийг



		<p>зохион байгуулснаар хоршоод, холбоодын үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах, хоршоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн худалдааг зохион байгуулах, шинэ санаачлага, сайн туршлагыг хоршоод хоорондоо хуваалцах, шинэ технологи, оновчтой санаачлага гаргаж байгаа шинжлэх ухаан, технологийн чиглэлээр ажилладаг байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах боломжийг нээж өгөх ач холбогдолтой боллоо. Арга хэмжээнд аймаг орон нутаг, нийслэлийн хоршоод, хоршоог дэмжигч байгууллагууд оролцож, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцууллаа.</p> <p>❖ Хөтөлбөрийн хугацаанд иргэдийн орлого, амьдралын чанар дээшлүүлэх зорилгоор Хадгаламж зээлийн хоршооны гишүүдэд хуримтлалын тухай, зээлийн ухаалаг зарцуулалт, санхүүгийн боловсролын бусад шат дараалсан сургалтуудыг тогтмол явуулж ирсэн.</p> <p>❖ Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх, өргөжүүлэх, тогтворжуулах зорилгоор хот, орон нутгийн хоршоодын ажилтан, удирдлагад шаталсан сургалтыг жил бүр зохион байгуулж ирсэн.</p> <p>❖ Шинээр байгуулагдаж буй Хадгаламж зээлийн хоршоодыг бойжуулан дэмжиж, “Дэм дэмэндээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж, үнэ төлбөргүй зөвлөх үйлчилгээ үзүүлж ирсэн. Хөтөлбөрийн хугацаанд Хадгаламж зээлийн хоршоодыг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дорвитой дэмжиж чадаагүй хэдий ч Хадгаламж зээлийн хоршооны салбарын хөрөнгийн чадавхи, гишүүдийн тоо өсч, гишүүдийн идэвхи санаачлага байнга өсч ирсэн.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p>
<b>2 дугаар зорилтын дундаж үнэлгээ: 90</b>		
Зорилт-3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлж, үр дүнг тодорхой тооцдог болгох;		<p><b>3.1. Нийслэл, аймаг бүр хоршоо хөгжүүлэх дэд хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;</b></p> <p>❖ Улсын хэмжээнд 21 аймаг 9 дүүрэгт Хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж ирлээ. Тухайлбал:</p> <p>❖ Баян-Өлгий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009-02-03-ны өдрийн 153 дугаар тогтоолоор “Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр II”-ийг 2009-2017 оны хооронд хэрэгжүүлэхээр батлуулсан. Тус хөтөлбөрийн дагуу жил болгон хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн байна. Мөн сум болгон “Хоршоог хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр II”-ийн хүрээнд сумын хоршоог хөгжүүлэх хөтөлбөрийг Сумдын ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан хэрэгжилтийг хангаж ажилласан байна.</p> <p>❖ Хоршоодын санхүүгийн чадавхийг дээшлүүлэх зорилтын хүрээнд 2013-2016 оны хооронд Жижиг, дунд үйлдвэрийн сангаас 7 хоршоод 160,0 сая, Сум хөгжүүлэх сангаас 47 хоршоод 390,4 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгогдсон байна. Тус аймагт 2015 оны байдлаар 8043 гишүүнтэй 296 хоршоо идэвхитэй үйл ажиллагаа явуулж 2 592,5 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.</p> <p>❖ Говь-Алтай аймгийн хувьд 127 хоршоо 6916 гишүүн өрхтэй 2,1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа явуулж байна. Хоршооллын хөгжилд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх төр, төрийн бус байгууллага, хоршооллын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Баруун бүсийн хөдөө аж ахуйн</p>

	<p>хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд Ховд, Увс, Говь-Алтай аймгийн хоршоодын удирдлага, гишүүн 60 гаруй хүн оролцож хоршоодод тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх ажлын талаар хэлэлцэн зөвлөмж гаргав.</p> <p>❖ Каритас Монгол ТББ-аас хэрэгжүүлж буй ХАА-ннэвтрүүлэхүйлчилгээг хөгжүүлэх, хоршооныхогжлийг дэмжих чиглэлээр Европын холбооны төсөлд хамруулаад байна. Тус төсөлд хоршоод хамрагдсанаар хоршооны менежментийн бүртгэл, санхүү, бизнес төлөвлөлт, органик газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сургалтанд хамрагдах, нарны эрчим хүчээр ажиллах хүлэмж барих технологид суралцах, санхүүжилт авах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, газар тариалангийн багаж хэрэгслүүдээр хангагдаж байна. Тус төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд 8 сумын 31 хоршооны удирдлага, гишүүдийг чадавхжуулах сургалтад хамрагдаж 200 орчим сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 90</i></p> <p><b>3.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг дүгнэхдээ хоршооны хөгжилд оруулсан хувь нэмрийг нэг шалгуур болгох;</b></p> <p>❖ Хөдөлмөрийн сайд, Аж үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын аймаг нийслэлийн засаг дарга нартай байгуулах гэрээнд хоршоог хөгжүүлэх дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх, аймаг орон нутгийн мэдэлд байгаа ашиглагдаагүй барилга, байшинг үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор эзэмшүүлэх, ашиглуулж үр дүнг тооцох тухай заалтыг тусган дүгнэж ирлээ. Тухайлбал: Говь-Алтай аймгийн Хөдөө аж ахуйн газрын хуучин байрыг аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбоонд шилжүүлж 35 сая төгрөгийн засварыг Каритас Монгол ТББ-ын санхүүжилтээр хийж тус төслөөс тоног төхөөрөмжөөр бүрэн хангаад байна.</p> <p>❖ Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Ахши хоршоо, Ногоонуур сумын Хошуу хоршоод сумын тамгын газрын байрыг ашиглан хүнсний болон гэр ахуйн барааны Хоршооны нэрийн дэлгүүр ажиллуулж байна.</p> <p>❖ Говь-Алтай аймгийн төвд хоршоодын бүтээгдэхүүний борлуулах зорилгоор “Алтайн бренд” бүтээгдэхүүний дэлгүүрийг 2015 оноос эхлэн Хөдөлмөрийн хэлтэс, Хоршоодыг дэмжих төсөлтэй хамтран нээн ажиллуулж байна</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p> <p><b>3.3. Хоршоо хөгжүүлэх чиглэлээр төрийн гүйцэтгэх зарим үүргийг гэрээний үндсэн дээр хоршоодын холбоодоор гүйцэтгүүлэх;</b></p> <p>❖ Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоогоор доорх ажлыг хийж гүйцэтгүүлээ.</p> <p><u>Үүнд:</u></p> <p>❖ Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/148 тушаалаар Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн хэлтсийн хоршоо, ахуйн үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд салбарын мэдээлэл, анхан шатны ойлголт өгөх, “Төрөөс хоршоо, ахуйн үйлчилгээний салбарын талаар баримталж буй бодлого”-ын талаар мэдээлэл хийх сургалтыг 2013-07-16-наас 18 өдрүүдэд зохион байгуулав. Сургалтанд 30 мэргэжилтэн оролцож салбарын</p>
--	---

	<p>мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэв.</p> <p>❖ Хоршооллын өдрийн арга хэмжээний хүрээнд “Хоршооллын бизнес хямралын үед ч хүчээ алддаггүй” өдөрлөг зохион байгууллаа. Арга хэмжээнд анхан болон дунд шатны хоршоо, аймаг орон нутгийн хоршоо дэмжигч байгууллага, төрийн болон хоршоодын холбоодын төлөөллийг оролцуулан нийт 40 хүн оролцлоо. Өдөрлөгийг Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны Хустайн байгалийн цогцолборт газрын орчны бүсэд нутаглаж буй малчдаас бүрдсэн малчдын бүлгүүдийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж оролцогч хоршоод, бүлгүүд харилцан туршлага, мэдээлэл солилцов.</p> <p>❖ ”Хоршооллын салбарын түншлэл” сүлжээ уулзалтыг 2014-09-10 өдөр хоршоод, хоршоодыг дэмжигч гадаадын төсөл хөтөлбөр уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар Монголын хоршооллын хөгжилд тулгамдаж буй чухал асуудлуудын талаар хэлэлцэх боломжийг хоршооллын салбарт үйл ажиллагаа явуулагч харилцан адилгүй үүрэг бүхий олон гишүүдэд Хоршооллын салбарт түншлэл, хамтын ажиллагааны шинэ хэлбэр СҮЛЖЭЭ үүсгэн байгуулах талаар тохиролцлоо.</p> <p>❖ Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/151 тоот тушаалаар 2014-09-16-20 өдрүүдэд болсон Ази, Номхон далайн бүсийн хоршоологчдын 11 дүгээр чуулганд Монгол улсыг төлөөлж хоршоодын холбооны төлөөлийг оролцуулах ажлыг зохион байгууллаа. Чуулганд хөтөлбөрийн дагуу оролцож нээлтийн үйл ажиллагаанд “Монгол улсад хоршооллын хөгжил, өнөөгийн байдал, цаашид хоршооллын талаар авах арга хэмжээ” талаар илтгэл тавьж оролцогчдын сонирхсон асуултанд хариулт өгч оролцсон байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:90</i></p> <p><b><i>3.4. Хувиараа болон өрхийн, эсхүл нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхэлж байгаа иргэдийг дэмжих бодлого, үйл ажиллагааны чиглэлээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Жижиг, дунд үйлдвэрийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сантай гэрээ байгуулж, хамтран ажиллах;</i></b></p> <p>❖ Олон улсын хоршооллын жилийн хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг хөдөлмөрөө хорших, зах зээлд нэгдсэн зохион байгуулалттай гаргах, төрөөс хөдөө орон нутагт чиглэсэн арга хэмжээг зохион байгуулалттай сүлжээгээр дамжуулан хэрэгжүүлэх, биржийн тогтолцоог байгуулах бэлтгэл ажлыг эрчимжүүлэх, сумдын эдийн засгийн бие даасан байдлыг хангах зорилгоор “Хөдөөг хоршоолох аян”-ыг эхлүүлж, Хоршоологчдын үндэсний III чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоохамтран ажиллахаар “Санамж бичиг”-ийг байгуулав.</p> <p>❖ Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэгч 47 фермд 38.5 тэрбум, махны үйлдвэрлэлийн 202 аж ахуй нэгжид 36.8 тэрбум, үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны зорь байгуулах 27 аж ахуй нэгжид 78.3 тэрбум, махны төрөлжсөн агуулах бүхий бөөний худалдааны төв болон махны чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулах 23 аж ахуй нэгжид 74.9 тэрбум төгрөгийн зээл олгож, үйлдвэрлэлийн кластерт ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагыг зээл, санхүүгийн бодлогоор дэмжсэний үр дүнд эдийн засгийн хямралын үед хөдөө аж ахуйн салбарын олон мянган ажлын байрыг тогтвортой хадгалж чадсан.</p> <p>❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй төсөл,</p>
--	--

	<p>хөтөлбөрөөр дамжуулан 10.4 мянган иргэнд 41 тэрбум төгрөгийн жижиг зээл олгосны дүнд 25.7 мянган ажлын байрыг шинээр бий болгосон. Энэ чиглэлээр Азийн хөгжлийн банкны “Ажлын байр нэмэгдүүлэх”, Хөдөө аж ахуйн олон улсын сангийн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслүүдтэй хамтран ажиллаж байна. Түүнчлэн 1.4 мянган ажил олоход хүндрэлтэй иргэнийг ажлын байртай болгож, тогтвортой хадгалсан 1.2 мянган аж ахуйн нэгжид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>❖ Жижиг, дунд үйлдвэрийг 2014-2016 онд хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, Сум хөгжүүлэх сангаас 312 тэрбум төгрөгийн зээл олгон, Зээлийн батлан даалтын сангаас 439 иргэн, аж ахуйн нэгжид 37.7 тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт гаргаснаар жижиг, дунд үйлдвэрүүд 36.5 мянган ажлын байрыг шинээр бий болгосны 52 хувь нь байнгын ажлын байр байсан.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p> <p><b>3.5. Хоршооны удирдлага, боловсон хүчнийг сургах, туршлага солилцох зорилгоор хоршоологчдын чуулганыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах;</b></p> <p>❖ Хоршоод хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, харилцан туршлага солилцох, бүтээгдэхүүнээ зах зээлд хамтран борлуулах боломжийг хөгжүүлэх зорилгоор 2 жилд нэг удаа Үндэсний хоршоологчдын чуулга уулзалтыг зохион байгуулж байна. Бүх төрлийн хоршоодын төлөөлөл нэг дор цуглаж тулгамдсан асуудлаа ярилцаж шийдвэр гаргадагаараа энэхүү чуулган онцлог юм. Үндэсний хоршоологчдын II чуулганыг “Хоршооллын салбарын дунд хугацааны стратеги”, III чуулганыг “Хөдөөг хоршоолох аян”, IV чуулганыг “Тогтвортой хөгжилд хоршоодын гүйцэтгэх үүрэг”, V чуулганыг “Хоршооны бизнесийн хөгжлийн гарц” сэдвийн хүрээнд зохион байгуулж ирлээ.</p> <p>❖ Хадгаламж зээлийн хоршооллын салбар “Тогтвортой хөгжил” үндэсний анхдугаар форумыг 2014 онд, “Хөгжлийн төлөө хамтдаа” үндэсний 2-р форумыг 2016 онд зохион байгуулж, хоршоодын хөгжлийн бодлогын чухал асуудлуудыг хэлэлцүүлэв.</p> <p>❖ Хөдөлмөрийн яам Монголын Хоршооллын Сургалт, мэдээллийн төв, Австрийн Клагенфуртын Их сургуулийн нэр бүхий хоёр профессортой уулзаж санал солилцсоноор Монголын хоршооллын ирээдүйн хөгжилд ач холбогдолтой хоёр зорилгод төвлөрөн “Байгууллагын хөгжил ба манлайлал” сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулахаар төлөвлөсөн. 1- дүгээр шат буюу “Манлайллаар мэргэших ажлыг (менежер болон сургагч багш нар) байгууллагын хөгжлийн нийгмийн ур чадвар, зарчим, арга барилын чиглэлээр сайжруулах” сэдвээр сургалтыг 2013 оны 10 дугаар сарын 3-6 өдрүүдэд хоршоодын холбоодын удирдлага, менежер, хоршооны сургагч багш, зөвлөхүүд, хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөл, хоршоодын төлөөлөл оролцсон 14 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.</p> <p>❖ Хөдөлмөрийн яам, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлж, нийгэмд гүйцэтгэх үүргийг нь сурталчлах зорилгоор гишүүн хоршоологчдод харилцан мэдээлэл, туршлага солилцох боломж бүрдүүлэх, тэдэнд сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх хүрээнд “Хоршоологчдын харилцан туршлага солилцох, хамтын</p>
--	---

		<p>ажиллагааг бэхжүүлэх, бүсчилсэн үзүүлэх сургууль”-ийг Дорнод, Говь-Алтай, Увс, Өвөрхангайд хоршоологчид хоршоог дэмжигч байгууллагыг оролцоотойгоор зохион байгууллаа.</p> <p>❖ Олон улсын Хоршооллын Алянсын Ази Номхон далайн бүсийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн хүрээнд “Хоршооллын бизнест эмэгтэйчүүдийн үүргийг нэмэгдүүлэх нь” бүсийн уулзалтыг улс орнуудын хооронд туршлага судлах зорилгоор 1 өдрийн семинар, 2 өдрийн хоршоодын үйл ажиллагаатай танилцах нийт 3 өдрийн арга хэмжээг зохион байгуулав. Арга хэмжээг Олон улсын Алянсын гишүүн хоршооллын байгууллага, хоршоодын удирдлагын 10-12 хүн, Монгол талын төлөөлөл бүхий нийт 50 хүний бүрэлдэхүүнтэй зохион байгууллаа.</p> <p>❖ Монголын худалдаа эд хэрэглэгчдийн хоршоодын Төв холбоо сүүлийн жилүүдэд худалдаа, үйлчилгээний ажлыг боловсронгуй болгох, худалдаа үйлчилгээг мэргэжлийн хүнээр эрхлүүлэх зайлшгүй шаардлагыг нийтэд ойлгуулан, мэргэжлийн худалдагч бэлтгэх сургалтыг Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Дэлхийн зөн, аймгуудын худалдаа эд хэрэглэгчдийн холбоодтойгоо хамтран зохион байгуулж ажиллаж байна. Энэ хугацаанд төв орон нутаг дахь өөрийн гишүүн байгууллагуудтай хамтран худалдагчийн сургалт зохион байгуулж, нийт 26 сургалтаар 600-аад мэргэжлийн худалдагч бэлтгэсэн байна.</p> <p>❖ Хоршооны болон аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах нийт 7 сургалтанд 675 хүн хамруулсан байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:100</b></p> <p><b>3.6. Хөдөө аж ахуйн хоршоодод үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад нь шаардагдах бэлчээр, газар, тариалангийн талбай, түүний орчмын нутгийг эзэмшүүлж, байгалийн нөөц баялгийг нь хамгаалан ашиглах эрх олгох.</b></p> <p>❖ Аймаг орон нутгийн мэдэлд байгаа ашиглагдаагүй барилга, байшинг үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын үйл ажиллагааг дэмжих зорилгоор эзэмшүүлэх, ашиглуулж үр дүнг тооцох тухай заалтыг тусган дүгнэж ирлээ.</p> <p>❖ 2014 онд Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж, Хадгаламж зээлийн хоршоотой хамтран ажиллах анхны гэрээг байгуулсан. Энэ хүрээнд Баянгол дүүргийн 21, Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар, Баянзүрх дүүргийн 8 дугаар, Сүхбаатар дүүргийн 17 хороонд хорооны хуучин байрыг ашиглан Хоршооны дэлгүүр ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ: 50</b></p>
		<b>3 дугаар зорилтын дундаж үнэлгээ: 83.3</b>
Зорилт 4. Хоршоодын бүтээгдэхүүнийг борлуулах сүлжээг бий болгох;		<p><b>4.1.Хандивлагчидтай хамтран хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр төсөл хэрэгжүүлэх;</b></p> <p>❖ Сум орон нутгийн иргэдийн таатай амьдрах боломжийг бүрдүүлэхэд шаардлагатай ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүдийн тоог нэмэгдүүлэн, үйлчилгээг ойртуулах, ажилгүйдэл ядуурлыг бууруулах, албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөө орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг багасгах зорилгоор Засгийн газрын 2014 оны 279 дүгээр тогтоолоор “Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааг зохион байгуулах, тайлагнах журам, санхүүгийн түрээсийн үйлчилгээний гэрээ, гурван талт гэрээний загваруудыг боловсруулж Хөдөлмөрийн сайдын 2014 оны А/221 тоот тушаалаар батлуулж хэрэгжүүлсэн</p>



байна. Хөтөлбөрийн үр дүнд шинээр 138 суманд ахуйн үйлчилгээний төв байгуулагдан, энэхүү төвүүдэд 1080 шинэ ажлын байр бий болсон байна.

*Үнэлгээ:50*

**4.2. Хөдөөгийн иргэдийн бэлтгэсэн түүхий эд, бүтээгдэхүүнийг хэрэглэгчид шууд худалдаалах зорилгоор мэдээллийн технологид суурилсан биржийг аймгуудад байгуулах;**

✓ Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийг 2011-06-02 нд, тус хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай УИХ-ын 2011-06-02 –ний өдрийн 29 дугаар тогтоол баталсан.

❖ Жижиг, дунд үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог сайжруулах зорилгоор 21 аймгийн 137 суманд ахуйн үйлчилгээний цогцолборыг, үндэсний хэмжээнд бараа бүтээгдэхүүн борлуулах 50 төвийг байгуулж, 15 аймагт брокерийн компаниуд байгуулагдсаны зэрэгцээ дотоодод үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд худалдан борлуулах тогтолцоог бий болгоход түлхүү анхаарч байна.

**Биржээр арилжаа /2013-2015 он/:**

Бараа	2013	2014	2015
Ямааны ноолуур /тн/	6382,1	6123,7	6877,0
Хонины ноос /тн/	1005,4	7641,3	10710,8
Тэмээний ноос /тн/	1048,0	1025,6	433,9
Ямааны завод ноос /тн/	-	1546,2	1954,8
Тэмээний завод ноос /тн/	-	24,0	19,0
Хонины завод ноос /тн/	-	878,3	699,6
Тосны ургамал /тн/	14,912	12,535	-
Амьд хонь /толгой/	-	12,0	-
Хүнсний буудай /тн/	-	-	1576,0

*Мэдээллийн эх сурвалж: Хөдөө аж ахуйн бирж*

*Үнэлгээ:90*

**4.3. Аймаг, сумдад хоршооны нэрийн барааны дэлгүүр ажиллуулах;**

❖ Аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулах гэрээнд хоршооны нэрийн барааны дэлгүүр байгуулах талаар тусгаж ажилласан.

❖ Нийслэлийн дүүрэг тус бүрт нэг хороог сонгон авч “Загвар хэрэглэгчийн хоршоо”-г байгуулан, нийслэлийн иргэдийг дундын олон шатлалт зуучлалгүй хямд бараа бүтээгдэхүүнээр хангах борлуулалтын сүлжээ сувгийг нээх замаар үйлдвэрлэгчийн хоршоодтой холбох зорилгоор Хөдөлмөрийн яам, Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны хамтарсан баг дүүргүүдийн удирдлагууд, хорооны дарга нартай нэгдсэн уулзалт, хэлэлцүүлэг хийж санал солилцон, загвар хороодыг сонгож эхний байдлаар Баянгол дүүргийн 21, Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороодод хэрэглэгчийн хоршоод байгуулагдан хоршооны дэлгүүр байгуулан хэрэглэгчдийг хямд үнийн бараа бүтээгдэхүүнээр хангаж байна.. “Загвар хэрэглэгчийн хоршоо” байгуулах үйл ажиллагааг нийслэлээс хоршсон хөдөлмөрийг дэмжих талаар баримталж буй бодлого, “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”, “Амьжиргааны доод түвшнээс бага орлоготой иргэдийг хямд үнэтэй бараа бүтээгдэхүүнээр хангах”

		<p>асуудалтай уялдуулан зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:70</i></p> <p><b>4.4. Хоршооны үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, туршилага солилцох зорилгоор дотоодын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцуулах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Хоршоодын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, харилцан туршлага солилцох зорилгоор дараах үзэсгэлэн худалдаанд хоршоодыг өргөнөөр оролцууллаа. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>❖ “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдаанд 19 хоршоо, Олон улсын хоршооллын жил”, “Хөдөөг хоршоолох аян”, “Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн болон бичил бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний бүтээгдхүүн, үйлчилгээг сурталчлах зорилготой “ХОРШОО-ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР-2012” үзэсгэлэн, худалдаанд Улаанбаатар хот, 21 аймгийн 500 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоологчид, өрхийн гар үйлдвэрлэгчид оролцож бараа бүтээгдхүүнээ хэрэглэгчдэд танилцуулж, борлуулав.</li> <li>❖ Орон нутагт аймаг бүр “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний дэд хөтөлбөр”-ийн хүрээнд хоршоо, Жижиг, дунд үйлдвэрийн үзэсгэлэн, худалдааг зохион байгуулж, хэрэглэгчдэд орон нутгийн хоршоо, Жижиг, дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулж борлуулсан байна.</li> <li>❖ Хадгаламж зээлийн хоршооны гишүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг сурталчлах, яармаг худалдаа зохион байгуулах ажлыг тогтмол хэрэгжүүлж ирсэн.</li> <li>❖ 2015 онд “Монголд үйлдвэрлэв-Цагаан сар-2015”, “Бүтээлч Монгол”, “Үндэсний нэрийн бүтээгдэхүүн” зэрэг үзэсгэлэнгүүдэд нийслэл, аймаг, орон нутгийн 19 хоршоодыг хамруулж борлуулалтыг дэмжиж ажиллалаа.</li> <li>❖ Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлд хамтран ажиллах зорилготой “Монгол Хятадын хамтарсан анхдугаар экспо” үзэсгэлэн Өвөрмонголын өөртөө засах орны нийслэл Хөх хотод 2015 оны 10 дугаар сарын 22-27 өдрүүдэд зохион байгуулагдсан. Энэхүү үзэсгэлэн худалдаанд анхан шатны хоршоод бүтээгдэхүүнтэйгээ оролцох бололцоог хангаж ажиллав.</li> <li>❖ Хоршоодын бүтээгдэхүүн борлуулах онлайн худалдааны веб хуудасны загвар дизайныг гаргаж туршилтаар ажиллуулав.</li> <li>❖ Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр II хүрээнд “Хоршоодын бүтээгдэхүүнийг нэгдсэн зах зээлд борлуулах сүлжээ” судалгааны ажил, “Малын гаралтай түүхий эдийн туршилтын борлуулалт”-ын үйл ажиллагааны үр дүнг танилцуулах хэлэлцүүлгийг 2011-01-01-нд зохион байгуулсан байна.</li> <li>❖ Хоршоолын шилдэг бүтээгдэхүүний каталоги гаргаж олны хүртээл болгов.</li> </ul> </li> </ul> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p>
		<b>4 дүгээр зорилтын дундаж үнэлгээ: 77.5</b>
	<p><b><u>Зорилт 5.</u> Хоршоодын мэдээллийн нэгдсэн санг баяжуулж, сургалт, сурталчилгааг төгөлдөржүүлэх.</b></p>	<p><b>5.1. Хоршооны талаархи ойлголт, түүний ач холбогдлыг таниулах анхан шатны сургалт, зөвлөх үйлчилгээ, үзүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулах;</b></p> <ul style="list-style-type: none"> <li>❖ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх үүднээс 2013-2014 онуудад 340 аж ахуйн нэгжээр мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, дээшлүүлэх богино хугацааны сургалтыг, аж ахуй эрхлэлтийн 41 төв, 19 бизнес инкубатор төвөөр дамжуулан бизнесийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг гэрээгээр гүйцэтгүүлж,</li> </ul>

	<p>төрөөс санхүүжүүлэх замаар <b>29.4</b> мянган хүнийг хамруулснаар 61 хувь нь ажлын байртай болсон.</p> <p>❖ Засгийн газраас “Хөдөөг хоршоолох аян”-ыг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр зарласан бөгөөд тус аяны хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын хоршоологчдын үндэсний нэгдсэн холбоо болон хоршооллын мэргэжлийн холбоод хамтран 2012 оны 4, 5-р сард “үндэсний хоршоодын үнэлгээ”-г газар дээр нь зохион байгуулав. Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээнд 21 аймаг, 330 сумдын 12427 хүн хамрагдсан байна.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 100</i></p> <p><b>5.2. Орлого багатай шинээр байгуулагдаж байгаа хоршоод болон нийгмийн эмзэг бүлгийн гишүүдээс бүрдсэн хоршоог бие дааж ажиллах чадвартай болгон бойжуулах төрөлжсөн инкубацн үйлчилгээг Монголын хоршооллын сургалт мэдээллийн төв, Хоршоо дэмжих төв, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвтэй хамтран бүсчлэн зохион байгуулах;</b></p> <p>❖ Нэгдсэн Үндэсний Байгууллагаас 2012 оныг Олон улсын хоршооллын жил болгон зарласан, Монгол улсын Засгийн газраас “Хөдөөг хоршоолох аян”-ыг эхлүүлж байгаа болон жишиг хоршоо хөтөлбөрийн талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор хэвлэлийн бага хурал хийж, арилжааны банкуудтай уулзалт зохион байгуулсан.</p> <p>❖ Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас Хөдөөг хоршоолох аянтай холбогдуулан өдөр тутмын сонингуудад тогтмол булан ажиллуулж байгаа бөгөөд энэхүү буланд Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо хоршоодын мэргэжлийн холбоодтой хамтран мэдээлэл бэлтгэж өдөр тутмын сонин хэвлэлд нийтэлж байв. Мөн “Хоршооллын мэдээ” сэтгүүлийг 2012 оны 1,2-р улиралд Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр ийн санхүүжилтээр хэвлэн гаргасан.</p> <p>❖ ОУ-ын хоршооллын жилийн хүрээнд хоршооллын салбараас зохион байгуулах ажлыг эрчимжүүлэх, Үндэсний хороотой хамтран ажиллах ажлын хэсгийг байгуулан ажилласан. Ажлын хэсгээс “Олон улсын хоршооллын өдөр”-ийг анхан болон дунд шатны хоршоод, төрийн байгууллагын төлөөлөл, хоршоо дэмжигч байгууллагууд, төсөл хөтөлбөр, Жижиг, дунд үйлдвэрийн газар болон зарим хоршоодын гишүүд орон нутгаас ирж өргөн тэмдэглэн өнгөрүүлсэн. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ОУ-ын хоршооллын жилийн хүрээнд ямар ажлууд хийгдэж байгаа, хоршооллын Олон улсын өдрийн талаарх мэдээлэл өгсөн. Өдөрлөгийн үеэр "Цэцээ гүн"-ий оргил өөд спорт явган аялал хийж, гар бөмбөг болон өөр олон төрлийн тэмцээн уралдаан болж оролцогчид өөрсдийн авьяас чадвараараа өрсөлдөв.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ: 70</i></p> <p><b>5.3. Хөрөнгө, хөдөлмөрөө хоршин амжилттай ажиллаж байгаа хоршоологчдын үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, сонирхогчдын захиалгаар хоршооны сургалтыг сонгон явуулах;</b></p> <p>❖ Монголын хадгаламж зээлийн үндэсний холбоо болон “Улаанбаатар Эрдэм” Их Сургуультай Хамтран ажиллах санамж бичгийг 2015-06-25-ны өдөр байгуулж, Хадгаламж зээлийн хоршоодод зориулсан тусгайлсан хөтөлбөрийг боловсруулж, хот хөдөөгийн Хадгаламж зээлийгнн хоршоодын боловсон хүчнийг</p>
--	--

	<p>бэлтгэх, чадавхижуулах ажиллагааг эхлээд байна. 2016 оны эцсийн байдлаар хот, хөдөөгийн хоршоодын удирдлага, ажилтануудаас бакалаврын эчнээд 16, магистрт 13 хүн суралцаад байна.</p> <p>❖ Хоршооллын салбарын хэмжээнд <a href="http://www.mongolia.coop">www.mongolia.coop</a>, <a href="http://www.namac.coop">www.namac.coop</a> гэсэн 2 цахим хуудас идэвхитэй ажиллаж хоршоо, хоршооллын хөдөлгөөний мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэж байна.</p> <p>❖ “Хоршооллын мэдээ” сэтгүүлийг 2012 оны 1,2-р улиралд Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр ийн санхүүжилтээр хэвлэн гаргасан.</p> <p>❖ Олон Улсын хоршооллын жил, Монгол улсын Засгийн газрын “Хөдөөг хоршоолох аян”-д зориулан Хоршооны салбарын түүхэн замналыг харуулсан “Эвийн хүч” баримтат киног хийлгэсэн.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p> <p><b>5.4. Хоршооны талаархи мэдлэгийг коллеж, их дээд сургууль, төрийн байгууллагын удирдах ажилтны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;</b></p> <p>❖ 2012 оноос хойшхи хугацаанд “Нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүрэг” сэдэвт шинжээчдийн бүлгийн уулзалтыг Монгол улсын “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”, Жижиг, дунд үйлдвэрийн газар, “Гадаад харилцааны яам”-наас НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхэлсэн газартай хамтран 2011 оны 5 сарын 3-6-ны хооронд Улаанбаатар хотод зохион байгуулсан. Дээрх олон улсын хуралд НҮБ, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Олон улсын Хоршооллын холбоо зэрэг байгууллагууд болон АНУ, Канад, ХБНГУ, Филиппин, Япон, Кени, ШведВьетнам улсын 50 орчим төлөөлөгчид, хоршооллын асуудлаар мэргэшсэн шинжээчид, НҮБ-ын агентлагууд, Олон улсын Хөдөлмөрийн байгууллага, хоршооллын байгууллагуудын төлөөлөгчид оролцлоо. Тус уулзалтаар “Олон улсын хоршооллын жил”-ийн зорилтуудыг батлах, 2012 онд хийх ажлын төлөвлөгөө болон 2012 оноос хойш авч хэрэгжүүлэх хэтийн төлөвлөгөөнд тусгах саналуудыг хэлэлцэж тодорхойлсон.</p> <p>❖ Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан “Олон улсын хоршооллын жил-2012”-ын нээлт, Монгол улсын Засгийн газрын 2012 оны 95 дугаар тогтоолоор баталсан “Хөдөөг хоршоолох аян”-ы нээлтийг Монголын хоршоологчдын 3-р чуулганы үеэр зохион байгуулсан. Энэхүү нээлт, чуулганд 21 аймаг, 330 сумдын Засаг дарга, хот, хөдөөгийн 400 гаруй хоршоологчид, дэмжигч гишүүд, төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, манай улсад суугаа олон улсын элчин сайдын яамд зэрэг нийтдээ 900 гаруй зочид, төлөөлөгчид оролцсон. Засгийн газраас “Хөдөөг хоршоолох аян”-ыг 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр зарласан бөгөөд тус аяны хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын хоршоологчдын үндэсний нэгдсэн холбоо болон хоршооллын мэргэжлийн холбоод хамтран 2012 оны 4, 5-р сард “үндэсний хоршоодын үнэлгээ”-г газар дээр нь зохион байгуулав. Аймаг бүрт зөвлөхийн баг ажиллаж хоршоо тус бүртэй биечлэн уулзаж, хоршооны хөгжлийг дэмжих чиглэлээр төрөөс авч хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, “Хөдөөг хоршоолох аян”-ы талаар танилцуулсан. Энэхүү ажлын удирдамжийг Жижиг, дунд үйлдвэрийн газар болон Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо хамтран боловсруулж, орон нутагт ажиллах багуудад зааварчилгаа,</p>
--	---

	<p>мэдээлэл өгөх уулзалт, семинаруудыг зохион байгуулж ажиллалаа. “Хөдөөг хоршоолох аян”-ы хүрээнд багууд орон нутагт 2012-04-22-оос 2012-05-24-нийг хүртэлх хугацаанд 21 аймгийн 330 сумдад ажиллав. Орон нутагт ажилласан багууд сургалт, мэдээлэл, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээг хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлжээ. Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, зөвлөх үйлчилгээнд 21 аймаг, 330 сумдын 12 427 хүн хамрагдсан байна. Энэхүү арга хэмжээ нь олон нийт, орон нутгийн удирдлагуудад хоршоо, хоршооллын хөдөлгөөний талаар үнэн зөв мэдээлэл түгээсэн чухал ач холбогдолтой болсон.</p> <p>❖ Аяны хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас “Үндэсний хоршоодын үнэлгээ”-ний үр дүнд сумдаас “жишиг хоршоо”-г тодорхой шалгууртайгаар сонгон шалгаруулж 2012 онд санхүүгийн дэмжлэгийг 107 хоршоонд үзүүлсэн байна.</p> <p>❖ Аймаг бүрт “Олон улсын хоршооллын жил-2012, “Хөдөөг хоршоолох аян”-ы нээлтийн ажлыг зохион байгуулж орон нутгийн иргэдэд хоршооны талаарх төрийн бодлого, хоршооны мөн чанар, үндсэн ойлголтын талаар мэдээллийг түгээсэн. Мөн орон нутагт аймаг, бүсийн хоршоодын бүтээгдэхүүний үзэсгэлэн, худалдааг зохион байгуулж ажилласан.</p> <p style="text-align: right;"><i>Үнэлгээ:100</i></p> <p><b>5.5. Хоршоо хөгжүүлэх чиглэлээр олон улсын сургалт, семинар, зөвлөгөөнийг хоршоодын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, хоршоодын хөгжлийн хүрээнд гадаад харилцааг өргөжүүлж, боловсон хүчин, мэргэжилтнийг олон улсын түвшинд мэргэшүүлж бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.</b></p> <p>❖ Хоршоо хөгжүүлэх чиглэлээр олон улсын сургалт, семинар, зөвлөгөөнийг Улаанбаатар хотноо зохион байгуулж, 5 орны 18, урилгаар 20 гаруй, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын Үндэсний холбооны ажлын албаныхан зэрэг нийт 50 төлөөлөгч оролцлоо. Уулзалтын төлөөлөгчид “Хоршооллын хөгжил, ирэх 10 жилд Ази тивд тулгарах сорилтууд” сэдвээр санал солилцож хамтран ажиллах тунхаг бичигт төлөөлөгчдийн тэргүүнүүд гарын үсэг зурж баталгаажуулсан.</p> <p>❖ Төрийн зохицуулагч байгууллага болох Санхүүгийн зрхицуулах хороотой Хамтран ажиллах санамж бичиг байгуулан, жил бүр хэрэгжилтийг дүгнэж ирсэн.</p> <p>❖ Монголын Хадгаламж зээлийн хоршоодын “Тогтвортой хөгжил” үндэсний анхдугаар форумыг 2014 онд, “Хөгжлийн төлөө хамтдаа” үндэсний 2-р форумыг 2016 онд зохион байгуулж, хоршоодын хөгжлийн бодлогын чухал асуудлуудыг хэлэлцүүлэн зохих төрийн байгууллагуудад нэгдсэн саналаа хүргүүлж ажилласан.</p> <p>❖ 2015 оноос Солонгосын Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоотой нягт хамтын ажиллагааг тогтоож, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөлдөж ажиллаж байна.</p> <p>❖ Монгол улсын Засгийн газрын “Хоршоо хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-2”-ийн төлөвлөгөөт ажлын хүрээнд нийт 15 сая төгрөгний санхүүжилтээр дараах ажлуудыг мэргэжлийн холбоод, Хоршооллын сургалт, мэдээллийн төв хариуцан зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Хоршоодын дарга, тэргүүлэгчдэд зориулсан сургалт</li> <li>➢ Хоршоодын бүсчилсэн сургалт</li> <li>➢ Дундын хоршоо үүсгэн байгуулах сургалт</li> <li>➢ Хоршоодын удирдах ажилтны зөвлөгөөн</li> <li>➢ Хэнтий аймагт Хадгаламж зээлийн хоршооны хуулийн</li> </ul>
--	---



	<p>үзэл баримтлал, тэдгээрийг эрсдэлээс хамгаалах талаар туршлага солилцох сургалт</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Сумдад жишиг хоршоо байгуулах сургалт</li> <li>➤ Хоршооны сургагч багш нарыг чадавхижуулах сургалт</li> <li>➤ Хоршооны сургалтын модулиудыг шинэчлэх зэрэг сургалт, чадавхижуулах ажлын үр дүнд нийт 350 орчим оролцогчид оролцож хоршооны сургалтын 4 модуль шинэчлэн боловсруулагдсан.</li> </ul> <p>❖ Орон нутагт өрнөж буй хоршоог дэмжих санал, санаачлагыг дэмжин аймаг, орон нутагт олон арван сургалт, зөвлөгөөн, хурал, чуулганд хоршоодын мэргэжлийн холбоодын төлөөлөл оролцож хоршооллын хөдөлгөөний талаар мэдээлэл хийж, хоршооны тухай анхан шатны ойлголтыг ард иргэдэд хүргэлээ. Төрийн байгууллага, яамдын нээлттэй өдөрлөгүүдэд идэвхитэй оролцож олон нийтэд хоршоо, хоршооллын хөдөлгөөний талаархи мэдээллийг хүргэв. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны нээлттэй өдөрлөг</li> <li>➤ Хөдөлмөрийн яамны нээлттэй өдөрлөг</li> </ul> <p>❖ Хоршооллын хөгжлийн бодлогыг тодорхойлоход чиглэсэн статистик мэдээллийг тогтмол гаргуулах, хоршооны талаарх судалгааг статистикийн мэдээлэлд оруулах асуудлаар Статистикийн Үндэсний Хороотой хамтран ажиллаж байна.</p> <p>❖ Монголын хоршооллын салбарын холбоод, хоршоодын төлөөлөл дараах Олон улсын арга хэмжээнүүдэд амжилттай оролцов. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Монголын хоршооллын холбоод болон төр засгийн төлөөлөл Нью-Йорк хотноо болсон “Олон улсын хоршооллын жил-2012”-ийн албан ёсны нээлтэд,</li> <li>➤ Тайланд улсын Бангкок хотноо 2 сарын 27-29-ны хооронд зохион байгуулагдсан “Хоршооны асуудал хариуцсан сайд нарын дээд хэмжээний уулзалтад Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны тэргүүн Н.Энхболд,</li> <li>➤ “Бүх Хятадын маркетинг, ханган нийлүүлэлтийн хоршоодын холбоо”-ноос зохион байгуулсан “Ази Номхон далайн бүсийн хоршоодын байгууллагуудын удирдлагуудын дээд хэмжээний уулзалт”-д Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбооны тэргүүн Н.Энхболд,</li> <li>➤ “Олон улсын хоршооллын Альянс”, “Бүх Хятадын Ханган борлуулалтын хоршоодын холбоо” хамтран "Хөдөө аж ахуйн хоршооллын маркетингийн чадавхийг бэхжүүлэх нь" сэдэвт Олон улсын сургалтад Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны /МХААХҮХ/-ны төлөөлөл,</li> <li>➤ “2012-Олон улсын хоршооллын жил”-ийн хүрээнд зохион байгуулагдсан нэг томоохон ажил болох 2012 оны 10-р сарын 30-аас 11-р сарын 3-ны өдрүүдэд Английн Манчестр хотноо хуралдсан Олон улсын хоршоологчдын их хурал,</li> <li>➤ Ази Номхон Далайн бүсийн хоршоодын 10 дахь удаагийн их хуралд МХААХҮХ-ны төлөөлөл,</li> </ul> <p>❖ Хоршоодын холбоод, хоршоологчид, хоршоог дэмжигч байгууллагуудын төлөөлөл Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага(ЈІСА)-аас Монгол улсад хэрэгжүүлж байгаа “Мал аж ахуй, газар тариалан хосолсон аж ахуйг</p>
--	--

		<p>хөгжүүлэх, экстеншний тогтолцоог бэхжүүлэх” төслийн багийн 2012 оны анхдугаар хуралд тус тус оролцов.</p> <p>❖ 2015 онд БНСУ-ын Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбоо (NACUFOK)–ны дарга төлөөлөгчдийг Монгол улсад 2 удаа урьж, албан ёсны уулзалт хийж, нягт хамтын ажиллагааг тогтоож, хоршоодын цаашдын хөгжил, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөлдөж ажиллаж байна.</p> <p>❖ Бүх аймгуудын удирдлагад хандан Хадгаламж зээлийн хоршоодыг дэмжихийг уриалсан албан бичгийг хүргүүлсэн. Хадгаламж зээлийн хоршоодын олон улсын өдөр болон Хуримтлалын олон улсын өдөр зэргийг жил бүр тэмдэглэн хоршооллын салбарыг олон нийтэд сурталчилж ирсэн.</p> <p>❖ Солонгосын Хадгаламж зээлийн хоршоодын үндэсний холбооноос бэлтгэсэн Дэлхийн болон Солонгосын хоршооллын хөдөлгөөний хөгжил, туршлагыг харуулсан “Чинээлэг амьдрал” 8 анги киноны 1, 8-р ангийг орчуулан хот, орон нутгийн Хадгаламж зээлийн хоршоодод хүргүүлсэн ба уулзалт, арга хэмжээний үеэр олон нийтэд үзүүлэн хоршооллын хөдөлгөөнийг сурталчилж байна.</p> <p style="text-align: right;"><b>Үнэлгээ:100</b></p>					
<b>5 дугаар зорилтын дундаж үнэлгээ: 94.0</b>							
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	<p>➢ Монголын хоршоодын Үндэснийнэгдсэн холбоо, аймаг орон нутаг дахь салбар байгууллагууд хоршооны хөтөлбөрийн хүрээнд сурагалт зохион байгуулах талаар сайн ажилласан байна.</p>					
	Дүгнэлт:(ололт, дутагдал, анхаарах асуудал)	<p>➢ Хөтөлбөр хэрэгжснээр хоршоо байгуулах оролцогчдын идэвх санаачлага нэмэгдэж хошоодын тоо, гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь өссөн үзүүлэлттэй байгаа хэдийч үйлдвэрлэлийн хэмжээ, бүтээгэдхүүн үйлдвэрлэл, гарсан үр дүн бүтээмжийн талаархи мэдээлэл дутуу байгааг;</p> <p>➢ Хоршооны удирдлага, гишүүдэд зориулсан сургалт болон гадаад, дотоодын Олон улсын байгууллагын сургалт, арга хэмжээ, хуралд хангалттай сайн хамрагдсан боловч түүний үр дүнд нэвтрүүлсэн шинэ санаа санаачилга, технологи, гарсан үр дүнгийн талаар мэдээлэл бага байгааг;</p> <p>➢ Хөтөлбөрийн зорилтод арга хэмжээнд аймаг тус бүр дэд хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэх талаар тусгасан бөгөөд энэ талаар тайланд мэдээлэл бага, орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах талаар дутагдалтай байгаа зэргийг анхаарч цаашид төгсгөлийн /2017он/ шатны тайланд бүрэн тусгаж ажиллахыг зөвлөж байна.</p> <p>➢ Бусад Хөтөлбөрүүдтэй харьцуулахад хамгийг их санхүүжилт авсан хөтөлбөрийн хувьд цаашид зарцуулсан санхүүжилтийг эх үүсвэр тус бүрээр, бүтээгэдхүүн үйлдвэрлэлтэй уялдуулан гаргаж тодорхой судалгаатай тайлагнах талаар анхаарч ажиллахыг зөвлөж байна.</p>					
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5
	<b>Хувиар</b>	<b>85.0</b>	80	90	83.3	77.5	94.0
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ:					
		... %					